



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 2/135

Хэрлэн сум

**3.Төмөрхуягийг ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, зарим яамдын нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан чиг үүрэг шилжсэн тул Нийгмийн бодлогын хэлтсийн Зорилтот бүлгийн залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Зууннастын Төмөрхуягийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Комиссын дарга: Н.Зоригтбаатар Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Цэцэгсайхан Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Баяртуяа Нярав

3.3.Төмөрхуягийн ажлыг зохих хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Зоригтбаатар)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА